

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/66/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261628 Цахим хаяг: Chantsaldulamp@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Баасанцэнд Утас: 261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabq.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Албан шаардлага	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТХН	Төсөл Хэрэгжүүлэх Нэгж
ТУХ	Төслийн Удирдах Хороо
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СБТ	Санхүүгийн байдлын тайлан
САГ	Санхүүгийн аудитын газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ШХА	Шууд худалдан авалт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.02 № 06/306
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 411,051.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал

- Мөнгөн хөрөнгийн зарлагын журналд 3 байгууллага, 1 хувь зөвлөхийн 274,052.5 мянган төгрөгийн төлбөрийг и-баримтаар баталгаажаагүй, анхан шатны баримтын дутуу хангалтгүй ажил гүйлгээг бүртгэсэн;
- Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээр 136,999.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх тушаал, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын бүртгэл, тайлан, илтгэх хуудсыг аудитад ирүүлээгүй нь жилийн эцсийн тооллого хийсэн эсэхийг нотлох боломжгүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.3.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.4.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн ба зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Гадаад зээл, тусламжийн төслүүдийн үр ашиг, бүтээмжийг сайжруулах хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 24 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын 7.8-д гадаад зээл, тусламжийн төслүүдийг эрэмбэлэх, хэрэгжилт, ашиглалтыг сайжруулах, төслийн менежментийн тогтолцоонд өөрчлөлт оруулж, тусгайлсан төслийн нэгжүүдийг Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохион байгуулалтад шилжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын Их Хурлын 2024 оны 54, 81 дүгээр тогтоолоор гадаад зээлийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээг цаашид санхүүжүүлэхгүй байх чиглэл Засгийн газарт өгсөн. Иймд төслийн төлөвлөгөөнд тусгасан зөвлөх үйлчилгээнүүдийг эрэмбэлж, Дэлхийн банктай тохиролцсоны дагуу Төслийн Удирдах хорооны 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар нийт хэрэгжүүлэх 67 дэд төсөл, арга хэмжээг 59 болгон нэн шаардлагатай, хурдан хугацаанд хэрэгжих ажлуудыг нэмж, дахин төлөвлөсөн.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

“Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт дүнгээр 1,208 ахмадыг цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад хамруулсан байна. Ахмад настай иргэд нь эмзэг бүлэгт хамаарах бөгөөд төслийн хүртээмжтэй байх зорилтыг хангасан гэж дүгнэжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



[Handwritten signature] Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,709,089,369.02	11,718,847,105.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,709,089,369.02	11,718,847,105.04
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	12,709,089,369.02	11,718,847,105.04
31210	Төгрөг	58,870,256.79	91,821,648.44
31211	Төрийн сангийн харилцах	58,870,256.79	91,821,648.44
31220	Гадаад валют	12,650,219,112.23	11,627,025,456.60
31221	Төрийн сангийн харилцах	12,650,219,112.23	11,627,025,456.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	131,033,772.04	96,675,498.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	131,033,772.04	96,675,498.16
39200	Биет хөрөнгө	123,255,994.26	91,342,164.83
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	93,430,000.00	93,430,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,150,555.56)	(30,543,333.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,569,372.70	35,569,372.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(592,822.88)	(7,113,874.54)
39300	Биет бус хөрөнгө	7,777,777.78	5,333,333.33
39301	Программ хангамж	8,000,000.00	8,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(222,222.22)	(2,666,666.67)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	12,840,123,141.06	11,815,522,603.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,840,123,141.06	11,815,522,603.20
51	Засгийн газрын хувь оролцоо	12,840,123,141.06	11,815,522,603.20
51200	Хуримтлагдсан үр дүн	12,840,123,141.06	11,815,522,603.20
51210	Өмнөх үеийн үр дүн	-	12,840,123,141.06
51220	Тайлант үеийн үр дүн	12,840,123,141.06	(1,024,600,537.86)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	12,840,123,141.06	11,815,522,603.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	14,073,390,950.57	8,886,298,482.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,073,390,950.57	8,886,298,482.48
120	Нийтлэг татварын бус орлого	14,073,390,950.57	8,886,298,482.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,065,097,661.57	8,877,379,031.48
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,065,097,661.57	8,877,379,031.48
120009	Бусад орлого	8,293,289.00	8,919,451.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,240,032,357.78	10,424,940,043.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,112,751,586.51	2,137,189,245.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,112,751,586.51	2,128,670,566.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	396,226,264.52	362,148,874.53
210101	Үндсэн цалин	396,226,264.52	362,148,874.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,529,128.39	45,268,548.39
210201	Тэтгэврийн даатгалын зардал	34,392,200.00	34,906,667.27
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4,060,000.00	3,860,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,275,000.00	390,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,681,928.39	391,881.12
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	8,120,000.00	5,720,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,327,975.00	89,982,531.84
210304	Байрны түрээс	78,327,975.00	89,982,531.84
2104	Хангамж, бараа материалын зардал	6,310,772.34	8,459,036.00
210401	Бичиг хэрэг	4,740,372.73	5,101,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,570,399.61	3,357,686.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,584,000.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	-	2,584,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	576,391,845.60	1,585,869,304.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	576,391,845.60	1,579,423,284.96
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,446,020.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,965,600.66	34,358,270.88
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,965,600.66	34,358,270.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	8,518,678.45
2135	Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	8,518,678.45
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,518,678.45
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	127,280,771.27	8,287,750,798.18
2200	Дотоод эх үүсвэрээр	127,280,771.27	8,287,750,798.18
221001	Их засвар	-	8,287,750,798.18
222001	Хаагдсан данс	127,280,771.27	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	12,833,358,592.79	(1,538,641,560.75)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,764,548.27	514,041,022.89
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	6,764,548.27	514,041,022.89
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	6,764,548.27	514,041,022.89
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	12,840,123,141.06	(1,024,600,537.86)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	14,073,390,950.57	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,073,390,950.57	-
120	Нийтлэг татварын бус орлого	14,073,390,950.57	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,065,097,661.57	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,065,097,661.57	-
120009	Бусад орлого	8,293,289.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,106,785,985.85	2,102,830,971.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,106,785,985.85	2,102,830,971.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,106,785,985.85	2,094,312,295.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	396,226,264.52	362,148,874.53
210101	Үндсэн цалин	396,226,264.52	362,148,874.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,529,128.39	45,268,548.39
210201	Тэтгэврийн даатгалын зардал	34,392,200.00	34,906,667.27
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4,060,000.00	3,860,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,275,000.00	390,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,681,928.39	391,881.12
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	8,120,000.00	5,720,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,327,975.00	89,982,531.84
210304	Байрны түрээс	78,327,975.00	89,982,531.84
2104	Хангамж, бараа материалын зардал	6,310,772.34	8,459,036.00
210401	Бичиг хэрэг	4,740,372.73	5,101,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,570,399.61	3,357,686.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,584,000.00
210702	Дотоод албан томилолт	-	2,584,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	576,391,845.60	1,585,869,304.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	576,391,845.60	1,579,423,284.96
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,446,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	8,518,675.45
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	8,518,675.45
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,518,675.45
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,966,604,964.72	(2,102,830,971.17)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	264,280,143.27	8,287,750,798.18
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	264,280,143.27	8,287,750,798.18
2200	Дотоод эх үүсвэрээр	264,280,143.27	8,287,750,798.18
222001	Тоног төхөөрөмж	127,280,771.27	8,287,750,798.18
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	136,999,372.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(264,280,143.27)	(8,287,750,798.18)
14	Бусад эх үүсвэр	-	9,400,339,505.37
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	6,764,548.27	514,041,022.89

Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1451	Засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	8,886,298,482.48
145102	Бусад засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	8,886,298,482.48
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	6,764,548.27	9,400,339,505.37
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	12,709,089,369.72	(990,242,263.98)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	12,709,089,369.02
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,709,089,369.02	11,718,847,105.04

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-
Тайлант үеийн үр дүн	12,840,123,141.06	12,840,123,141.06	12,840,123,141.06
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	12,840,123,141.06	12,840,123,141.06	12,840,123,141.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,840,123,141.06	12,840,123,141.06	12,840,123,141.06
Тайлант үеийн үр дүн	(1,024,600,537.86)	(1,024,600,537.86)	(1,024,600,537.86)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,815,522,603.20	11,815,522,603.20	11,815,522,603.20

Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,544,329,000.00	10,382,072,093.90	162,256,906.10	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,244,329,000.00	2,094,321,295.72	150,007,704.28	93.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,244,329,000.00	2,094,321,295.72	150,007,704.28	93.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	365,000,000.00	362,148,874.53	2,851,125.47	99.2
210101	Үндсэн цалин	365,000,000.00	362,148,874.53	2,851,125.47	99.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,720,000.00	45,268,548.39	4,451,451.61	91.0
210201	Тэтгэврийн даатгал	34,910,000.00	34,906,667.27	3,332.73	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,860,000.00	3,860,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,825,000.00	390,000.00	1,435,000.00	21.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,825,000.00	391,881.12	1,433,118.88	21.5
210205	Эрүүл мэндийн даатгал	7,300,000.00	5,720,000.00	1,580,000.00	78.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,000,000.00	89,982,531.84	17,468.16	100.0
210304	Байрны түрээс	90,000,000.00	89,982,531.84	17,468.16	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,100,000.00	8,459,036.00	5,640,964.00	60.0
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	5,101,350.00	898,650.00	85.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,600,000.00	3,357,686.00	4,242,314.00	44.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	-	500,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,584,000.00	416,000.00	86.1
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,584,000.00	416,000.00	86.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,722,509,000.00	1,585,878,304.96	136,630,695.04	92.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,716,009,000.00	1,579,432,284.96	136,576,715.04	92.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,500,000.00	6,446,020.00	53,980.00	99.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,300,000,000.00	8,287,750,798.18	12,249,201.82	99.9
222001	Тоног төхөөрөмж	8,300,000,000.00	8,287,750,798.18	12,249,201.82	99.9
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(10,544,329,000.00)	(10,382,063,093.90)	(162,265,906.10)	98.5
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,544,329,000.00	10,382,063,093.90	162,265,906.10	98.5
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	1,495,764,611.42	(1,495,764,611.42)	(100.0)
72	Засгийн газрын зээл	10,544,329,000.00	8,886,298,482.48	1,658,030,517.52	84.3
722	Гадаад	10,544,329,000.00	8,886,298,482.48	1,658,030,517.52	84.3
7221	Төслийн зээл	10,544,329,000.00	8,886,298,482.48	1,658,030,517.52	84.3
322101	Шинээр авах	10,544,329,000.00	8,886,298,482.48	1,658,030,517.52	84.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	12,709,089,369.02	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	11,718,847,105.04	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЭЛИЙН АНГИЛАЛ				
61	Байгууллагын тоо	1	1	-	-
610001	Төсөл хэрэгжүүлэх нэгж	1	1	-	-
62	Ажилагсдын тоо	8	7	1	-
620001	Удирдах ажитан	1	1	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	7	6	1	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газар болон Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 2023-2027 онд Ухаалаг засаг-2 төслийг хэрэгжүүлэхээр 7090-MN зээлийн хэлэлцээрийг байгуулсан. Монгол Улсын дижитал засаглалыг цахимжуулалтын дараагийн үе шатанд хүргэж өргөжүүлэх, дижитал эдийн засгийг хөгжүүлэх асуудлын хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хэрэгжүүлэх төсөл юм.

Ухаалаг засаг-2 төслийн зорилго нь иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн цахим үйлчилгээний хэрэглээ, үр ашгийг сайжруулах, цахим ур чадвар болон дижитал технологи суурьтай ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

Ухаалаг засаг-2 төслийн үйл ажиллагааны чиглэл:

Бүрэлдэхүүн хэсэг 1. Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх

- Дижитал шилжилтийн талаарх бодлого, дүрэм, журмыг сайжруулах;
 - Дижитал шилжилттэй холбоотой хууль, эрх зүй, зохицуулалт, бодлого, институтийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүн шинжилгээ хийх, техникийн туслалцаа үзүүлэх;
 - Цахим шилжилт хийхэд шаардлагатай дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах.

Бүрэлдэхүүн хэсэг 2. Дижитал засгийн шилжилтийг нэвтрүүлэх

- Төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, үр ашигтай байдлыг дээшлүүлэх, стратегийн үйлчилгээ үзүүлэх
- Үндэсний дата төв болон түүний Нөөц дата төвийг шинэчлэх
- Үндэсний кибер аюулгүй байдлын онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах Мэдээллийн аюулгүй байдлын багийн чадавхыг нэмэгдүүлэх, Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг бэхжүүлэх

Бүрэлдэхүүн хэсэг 3. Дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих

- Төрийн албан хаагчид, иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх;
- Залуучуудад зориулсан дижитал технологид суурилсан ажлын байр бий болгох;

Бүрэлдэхүүн хэсэг 4. Төслийн удирдлага, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх

Бүрэлдэхүүн хэсэг 5. Онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах төлөвлөгөө

3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2024 оны 6 дугаар сард 6 дугаар зүйлийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”
- Сангийн сайдын 2025 оны 174 дүгээр тушаалаар баталсан “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам”

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаанд Дэлхийн банкны явцын хяналтууд хийгдэж, харьяа яамны хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,024,600.5 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,709,089.3	11,718,847.1	(990,242.2)
Үндсэн хөрөнгө	123,256.0	91,342.2	(31,913.8)
Биет бус хөрөнгө	7,777.8	5,333.3	(2,444.5)
Нийт хөрөнгө	12,840,123.1	11,815,522.6	(1,024,600.5)

/мянган төгрөг/

Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хуримтлагдсан үр дүн	12,840,123.1	11,815,522.6	(1,024,600.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,840,123.1	11,815,522.6	(1,024,600.5)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данстууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 11,718,847.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 990,242.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тоног төхөөрөмжийн гэрээний төлбөрүүд төлөгдсөнтэй холбоотой;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 91,342.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 31,913.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал тооцоолон бүртгэснээс шалтгаалсан;
- Хуримтлагдсан үр дүнгийн данс 1,024,600.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Ухаалаг засаг-2 төсөл нь 2024 оны 7 дугаар сарын 18-ны өдөр 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 82,497,385.4 мянган төгрөгөөр тооцон, гадаад зээлийн санхүүжилтээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас бусдаар гүйцэтгүүлэх бараа, ажил, үйлчилгээний зардлыг 12,255,327.5 мянган төгрөг, томилт зочны зардлыг 1,029,278.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж, эд хогшил засварын зардлыг 45,184.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 69,257,963.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Сангийн яамнаас 2024 оны 01/10803 дугаар албан тоотор УИХ-ын 2024 оны 54 дүгээр тогтоолын дагуу гадаад зээлийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал зэрэг урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх чиглэл ирүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 58,713,634.6 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг 10,544,329.0 мянган төгрөгийн гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаад зээлийн эх үүсвэрээс 8,886,298.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Нийт зардлын гүйцэтгэл 10,382,063.1 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 150,016.7 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 12,249.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70207-Гадаад зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр	10,544,329.0	10,382,063.1	162,265.9	98.5
1.1	80104-Гадаад зээлээр хэрэгжүүлэх арга хэмжээ	10,544,329.0	10,382,063.1	162,265.9	98.5

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан,

төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийн дагуу аудитын явцад тус төсөл хэрэгжүүлэгч нэгжээс дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.-

Байгууллагын орон тооны цомхотголын талаар:

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн батлагдсан орон тоо 8, гүйцэтгэлээр 7 хүнтэй ажиллаж, цалингийн зардалд 365,703.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 382,148.4 мянган төгрөгийг зарцуулсан.

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:

Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн 2 шатны сургалт зохион байгуулж, нийт 1,208 хүмүүсийг хамруулж, 21,400.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Гадаад томилолтын талаар:

Гадаад томилолтын зардалд 302,397.0 мянган төгрөгийн төсөв баталснаас, 4 удаагийн гадаад томилолтод 29 хүнийг хамруулж, 288,533.1 мянган төгрөгийг зарцуулсан.

Программ хангамжийн бүртгэл, тайлагналын талаар:

Төсөл хэрэгжүүлэгч нэгжид нийт 18,108.8 мянган төгрөгийн өртөгтэй, оффис 365, зүүм программ, санхүүгийн программ зэрэг 3 программ хангамжийг үйл ажиллагаандаа ашиглаж, 6,326.02 мянган төгрөгийг лицензийн төлбөрт төлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл эхэлснээс хойших хугацаанд төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 удаа өөрчлөлт оруулж сүүлийн байдлаар нийт төлөвлөгөөнд 67 дэд төсөл, арга хэмжээ тусгасан байсаныг 59 болгон цөөлж, нэн шаардлагатай, хурдан хугацаанд хэрэгжих ажлуудыг нэмж, дахин төлөвлөсөн. Төслийн хүрээнд 2025-2027 онд хэрэгжих нийт төлөвлөгөөнд 59 дэд төсөл, арга хэмжээ тусгаснаас 52 нь худалдан авалтыг зохион байгуулж, гэрээ байгуулан хэрэгжүүлэх дэд төсөл, 7 нь гүйцэтгэлээр чадавх бэхжүүлэх арга хэмжээ байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөг/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжи лтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Бүрэлдэхүүн хэсэг 1. Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх	2023-2027он	“цахим шилжилт хийх орчныг бүрдүүлэх” хэсгийн хүрээнд дижитал шилжилт, харилцаа холбооны салбарыг бодлого, журмыг бэхжүүлэх, Цахим шилжилт хийхэд шаардлагатай дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах, хууль тогтоомжийг сурталчлах зорилтын хүрээнд	100	575,902.0	575,902.0
2	Бүрэлдэхүүн хэсэг 2. Дижитал засгийн шилжилт	2023-2027он	“цахим шилжилтийн дэд бүтцийг сайжруулах” хоёрдугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд цахим үйлчилгээний нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэх, Үндэсний дата төв, түүний нөөц төвийг илүү боловсронгуй болгох, кибер аюулгүй ажиллагааг сайжруулах зорилтыг тавьсан.	100	8,988,062.4	8,974,091.3

Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	Бүрэлдэхүүн хэсэг 3. Дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих	2023-2027он	Төслийн “Дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих” гуравдугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төрийн албан хаагчдад, ахмад настай иргэдэд дижитал ур чадварыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах, дижитал суурьтай ажлын байрыг бий болгох замаар дэмжлэг үзүүлэх зорилтыг дэвшүүлж байгаа.	100	299,071.0	294,086.7
4	Бүрэлдэхүүн хэсэг 4. Төслийн менежмент, зохион байгуулалт	2023-2027он	Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Төслийн Удирдах хороо, төсөл хэрэгжүүлэгч, үр шим хүртэгч байгууллага, санхүүжүүлэгч талуудад дэд төсө, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулахад төслийн удирдлага, санхүү, худалдан авалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, байгаль орчин нийгмийн хамгаалал, техникийн, мэдээлэл харилцааны чиглэлээр зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	100	550,000.0	547,254.5
Дүн					10,413,035.4	10,391,334.6

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүснэгт 4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

/мянган төгрөг/

№	Худалдан авалт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь	Тоо	Мөнгөн дүн
1	НТШ-Дотоод	19	4,155,196.4	9	12,134,676.1	47.4	10	(7,979,479.7)
2	НТШ-Олон улсын	11	8,638,304.4	-	-	0.0	11	8,638,304.4
3	ШХА	6	3,450,266.5	4	295,424.1	66.7	2	3,154,842.4
Дүн		36	16,243,767.3	13	12,430,100.2	36.1	23	3,813,667.1

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 4,155,196.4 мянган төгрөгийн 19 дотоодын нээлттэй тендер шалгаруулалт, 8,638,304.4 мянган төгрөгийн 11 олон улсын нээлттэй тендер шалгаруулалт, 3,450,266.5 мянган төгрөгийн 6 шууд худалдан авалт, нийт 16,243,767.3 мянган төгрөгийн 36 бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг батлуулсан байна. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 9, шууд худалдан авалтаар 4 бараа, ажил, үйлчилгээний 12,430,100.2 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэл 36.1 хувьтай байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсөл хэрэгжүүлэгч нэгжид Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн мэдээлж, хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Ө.Ундармаа гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Үндэсний Аудитын Газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Т.Баасанцэнд, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Ухаалаг засаг-2 төсөл нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 12,447,784.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 124,477.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/23 тоот тушаалаар Солонгос улсын Сөүл хотноо зохиогдох арга хэмжээнд 15 хүний 110,500.8 мянган төгрөг, А/110 дугаар тушаалаар Канад улсад 6 хүний 112,899.5 мянган төгрөг, А/192 дугаар тушаалаар Герман улсад 6 хүний 52,323.2 мянган төгрөг, А/231 дугаар тушаалаар Туркменистан улсын Аваза хотод бага хуралд оролцох 2 хүний 16,573.4 мянган төгрөг, нийт 292,297.1 мянган төгрөгийн албан томилолтын зардлуудыг бусад яам, газрын албан тушаалтнуудад олгож, батлагдсан төсөв хэтрүүлээгүй боловч зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад албан томилолтын зардлаас гадны байгууллагын хүмүүсийн гадаад томилолтын зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоох, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 3 зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 23 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн хугацаа болон үнэн зөв байдлыг хянахад байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт, дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэсэн 8 мэдээг хугацаа хоцроож, мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэж заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн мэдээлж, хуулийн хэрэгжилтийг хангаж зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл

Илрүүлэлт: Төслийн удирдах хорооны 2025 оны 6 дугаар тогтоолоор баталсан тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 16,243,767.3 мянган төгрөгийн 36 бараа, ажил үйлчилгээ тусгагдсанаас гүйцэтгэлээр 12,430,100.2 мянган төгрөгийн 13 худалдан авалт зохион байгуулж, гэрээ байгуулсан нь 36.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх өмнөх оны аудитын зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан журмын 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төслийн хэрэгжих хугацаанд төлөвлөсний дагуу худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан асуудал нь холбогдох хууль тогтоомжийн шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчлийг давтан гарахгүй байх 482,489.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 79.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Зөвлөмж	3	482,489.7	2	482,489.7	79.0
	Нийт дүн	3	482,489.7	2	482,489.7	79.0

Төслийн удирдах хорооны 2025 оны 6-р тогтоолоор баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 36 тендер зохион байгуулахаар баталснаас 12,430,100.2 мянган төгрөгийн 13 гэрээ байгуулсан, өмнөх оны аудитаар батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгснийг хангалттай хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бэлтгэн нийлүүлэгч байгууллага, хувь зөвлөхүүдийн гэрээний хэрэгжилтийн бүртгэлийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлд нийцүүлэн бүртгэж, тайлагнасныг дараагийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 411,051.8 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс залруулагдаагүй 411,051.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 286,574.0 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Мөнгөн хөрөнгийн зарлагын журналд 3 байгууллага, 1 хувь зөвлөхийн 274,052.5 мянган төгрөгийн төлбөрийг и-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын дутуу хангалтгүй ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, төлсөн төлбөрийг и-баримтаар баталгаажуулан авч байх, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2. Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээр 136,999.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх тушаал, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын бүртгэл, тайлан, илтгэх хуудсыг аудитад ирүүлээгүй нь жилийн эцсийн тооллого хийсэн эсэхийг нотлох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна", 72.4.1-т "Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэсэн заалттай тус тус нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын тушаал, шийдвэр гаргаж, хуульд заасны дагуу хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, тооллогод хамрагдсан эд хөрөнгийг дансаар, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тайлан, илтгэх хуудсаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, цаашид хууль тогтоомж хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн хөрөнгийн зарлагын журналд 3 байгууллага, 1 хувь зөвлөхийн 274,052.5 мянган төгрөгийн төлбөрийг и-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын дутуу хангалтгүй ажил гүйлгээг бүртгэсэн байна.	1	274,052.5			1	274,052.5						
2	Санхүүгийн байдлын тайлан, Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээр 136,999.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх тушаал, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын бүртгэл, тайлан, илтгэх хуудсыг аудитад ирүүлээгүй нь жилийн эцсийн тооллого хийсэн эсэхийг нотлох боломжгүй байна.	1	136,999.3			1	136,999.3						
Дүн		2	411,051.8	-	-	2	411,051.8	-	-	-	-	-	-

Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн хугацаа болон үнэн зөв байдлыг хянахад Байгууллагын батлагдсан төсөв, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Худалдан авах ажиллагааны тайлан, Санхүүгийн тайлан, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт, Дараа жилийн төсвийн төсөл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэсэн 8 мэдээг хугацаа хоцроож, мэдээлсэн байна.	1	-					1	-
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
2	Төслийн удирдах хорооны 2025 оны 6 дугаар тогтоолоор баталсан тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 134,594,208.7 мянган төгрөгийн 36 бараа, ажил үйлчилгээ тусгагдсанаас гүйцэтгэлээр 12,430,100.3 мянган төгрөгийн 13 худалдан авалт зохион байгуулж, гэрээ байгуулсан нь 36.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх өмнөх оны аудитын зөвлөмж хэрэгжээгүй байна.	1	-			1	-		
3	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/23 тоот тушаалаар Солонгос улсын Сөүл хотноо зохиогдох арга хэмжээнд 15 хүний 110,500.8 мянган төгрөг, А/110 дугаар тушаалаар Канад улсад 6 хүний 112,899.5 мянган төгрөг, А/192 дугаар тушаалаар Герман улсад 6 хүний 52,323.2 мянган төгрөг, А/231 дугаар тушаалаар Туркменистан улсын Аваза хотод болох бага хуралд оролцох 2 хүний зардал 16,573.4 мянган төгрөг, нийт 292,297.1 мянган төгрөгийн албан томилолтын зардлуудыг УИХ гишүүд, СЯ болон ЦХИХХЯ-ны бусад албан тушаалтнуудад олгож, батлагдсан төсөв хэтрүүлээгүй боловч зориулалт бусаар зарцуулсан байна.	1	292,297.1			1	292,297.1		
Дүн		3	292,297.1	-	-	2	292,297.1	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1176/A0150061

Улаанбаатар хот

САГ - 2026/66/НА - СТА - ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төслийн удирдах хорооны 2025 оны 6 дугаар тогтоолоор баталсан тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 134,594,208,720.00 /нэг зуун гучин дөрвөн тэрбум таван зуун ерэн дөрвөн сая хоёр зуун найман мянга долоон зуун хорин/ төгрөгийн 36 бараа, ажил үйлчилгээ тусгагдсанаас гүйцэтгэлээр 12,430,100,351 /арван хоёр тэрбум дөрвөн зуун гучин сая нэг зуун мянга гурван зуун тавин нэгэн/ төгрөгийн 13 худалдан авалт зохион байгуулж, гэрээ байгуулсан нь 36.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх өмнөх оны аудитын зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан журмын 7 дугаар зүйлийн 7.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төслийн хэрэгжих хугацаанд төлөвлөсний дагуу худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ухаалаг засаг-2 төслийн зохицуулагч /Б.Энхдөлгөөн/, Санхүүгийн мэргэжилтэн /Ё.Оюун-Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-39.Docx

1526181818



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1177/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/66/НА-СТА-ТХИ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/23 дугаар тушаалаар Солонгос улсын Сөүл хотноо зохиогдох арга хэмжээнд 15 хүний 110,500,822.00 /нэг зуун арван сая таван зуун мянга найман зуун хорин хоёр/ төгрөг, А/110 дугаар тушаалаар Канад улсад 6 хүний 112,899,567.00 /нэг зуун арван хоёр сая найман зуун ерэн есөн мянга таван зуун жаран долоо/ төгрөг, А/192 дугаар тушаалаар Герман улсад 6 хүний 52,323,247.00 /тавин хоёр сая гурван зуун хорин гурван мянга хоёр зуун дөчин долоон/ төгрөг, А/231 дугаар тушаалаар Туркменистан улсын Аваза хотноо болох бага хуралд суух 2 хүний зардал 16,573,441.00 /арван зургаан сая таван зуун далан гурван мянга дөрвөн зуун дөчин нэгэн/ төгрөгийн албан томилолтын зардлуудыг бусад яам, газрын албан тушаалтнуудад олгож, батлагдсан төсөв хэтрүүлээгүй боловч зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гадаад албан томилолтын зардлаас гадны байгууллагын хүмүүсийн гадаад томилолтын зардлыг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ухаалаг засаг-2 төслийн зохицуулагч /Б.Энхдөлгөөн/, Санхүүгийн мэргэжилтэн /Е.Оюун-Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-39.Docx

1526181820



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1178/A0150061

Улаанбаатар хот

САГ - 2026/66/НА - СТА - ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн байдлын тайлан, Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээр 136,999,372.00 /нэг зуун гучин зургаан сая есөн зуун ерэн есөн мянга гурван зуун далан хоёр/ төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх тушаал, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тооллогын бүртгэл, тайлан, илтгэх хуудсыг аудитад ирүүлээгүй нь жилийн эцсийн тооллого хийсэн эсэхийг нотлох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна”, 72.4.1-т “Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.2-т “хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй”-д гэж заасныг үндэслэн тус тус **ШААРДАХ нь:**

1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын тушаал, шийдвэр гаргаж, хуульд заасны дагуу хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, тооллогод хамрагдсан эд хөрөнгийг дансаар, хөрөнгийн ангиллаар нэгтгэсэн тайлан, илтгэх хуудсаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ухаалаг засаг-2 төслийн зохицуулагч /Б.Энхдөлгөөн/, Санхүүгийн мэргэжилтэн /Ё.Оюун-Эрдэнэ/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-39.Docx

1526181816



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1179/АД150061

Улаанбаатар хот

САГ - 2026/66/НА - СТА - ТХИ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн зарлагын журналд 3 байгууллага, 1 хувь зөвлөхийн 274,052,543.00 / хоёр зуун далан дөрвөн сая тавин хоёр мянга таван зуун дөчин гурав / төлбөрийг и-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын дутуу хангалтгүй ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, төлсөн төлбөрийг и-баримтаар баталгаажуулан авч байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ухаалаг засаг-2 төслийн зохицуулагч /Б.Энхдөлгөөн/, Санхүүгийн мэргэжилтэн /Е.Оюун-Эрдэнэ/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-39.Docx

1526181814